



СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 06 сарын 12 өдөр

Дугаар А/83

Улаанбаатар хот

Орон нутгийн хөгжлийн сангийн  
хөрөнгөөр 2017 онд хэрэгжүүлэх  
хөрөнгө оруулалтын ажлын жагсаалтад  
өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.4 дэх заалт, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 3/13, Тэргүүлэгчдийн 2016 оны А/118, 2017 оны А/65 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Сонгинохайрхан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь :

1. Дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2017 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын ажлын жагсаалтад оруулах өөрчлөлтийг хавсралт ёсоор баталсугай.
2. Хөрөнгө оруулалтын ажлыг холбогдох хууль, журамд нийцүүлэн зохион байгуулж ажиллахыг дүүргийн Засаг дарга /Ж.Сандагсүрэн/-д үүрэг болгосугай.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэдэх Санхүү, эдийн засгийн хороо /Э.Батболд/-д даалгасугай.

ДАРГА



Б. МӨНХЦЭЦЭГ

Сонгинохайрхан дүүргийн Иргэдийн  
Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн  
2017 оны 06 дугаар сарын 12 н.ш. өдрийн  
1/22 дугаар тогтоолын хавсралт

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2017 онд  
хийгдэх ажлын жагсаалтад оруулах өөрчлөлт

Д/д	Оруулах өөрчлөлт
1	361-ийн гарамд хэсгийн байр барих, байршил 21 дүгээр хороо төсөвт өртөг 5.3 сая гэснийг хасах
2	Нарийны аманд хэсгийн байр барих, байршил 21 дүгээр хороо төсөвт өртөг 5.4 сая гэснийг 8.7 сая гэж өөрчлөх
3	Автомашин хурд сааруулагч, байршил 24-р хороо, төсөвт өртөг 5.0 сая гэснийг 7.0 сая гэж өөрчлөх
4	Автозам, зогсоол сайжруулах, байршил 3 дугаар хороо /65 дугаар сургуулийн баруун талын автозамаас 80 дугаар цэцэрлэг хүртэл/, төсөвт өртөг 35.0 сая гэснийг хасах
5	Жишиг гудамж байгуулах, байршил 26 дугаар хороо, төсөвт өртөг 30.0 сая гэж шинээр нэмэх
6	Сагсан бөмбөгийн талбай тохижуулах, 26 дугаар хороо, төсөвт өртөг 5.0 сая гэж шинээр нэмэх
7	Автозам засаж сайжруулах, байршил 8 дугаар хороо /Баянхошууны автозамаас 67 дугаар сургууль хүртэл/, төсөвт өртөг 10.0 сая гэснийг хасах
8	Сагсан бөмбөгийн талбай байгуулах 2ш, байршил 8 дугаар хороо, төсөвт өртөг 10.0 сая гэж шинээр нэмэх
9	Автомашин гарц гаргаж тохижуулах, байршил Цагдаагийн 1 дүгээр хэлтэс, төсөвт өртөг 10.6 сая гэснийг 15.0 сая гэж өөрчлөх
10	Улсын баяр наадмыг дүүрэгт тэмдэглэх, төсөвт өртөг 63.0 сая гэснийг 58.6 сая гэж өөрчлөх